



“ АРИГ ГАЛ “
ҮЙЛДВЭР ХУДАЛДААНЫ ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 03 дугаар
сарын 10- ны өдөр

Дугаар 08/20

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай:

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2 дахь заалт Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар мэдээг хүргэх журам”-ын 2.2 –д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Ариг гал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 04-р сарын 24-ны өдрийн 17 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн 15-р хороо, Үйлдвэрийн парк-1 хаягт байрлах компанийн байр. Хурлын танхимд хуралдуулсугай.
 2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурьдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:
 - 2.1 Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн талаарх гүйцэтгэх захирлын тайланг хэлэлцэж батлах;
 - 2.2 Компанийн 2019 оны үйл ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
 - 2.3. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;
 - 2.4. 2019 оны үйл ажиллагааны үр дүнгээр хуваарилах ногдол ашгийн хувь хэмжээг тогтоосон ТУЗ-ийн хурлын 07.20 тоот шийдвэрийг хэлэлцэж батламжлах.
 - 2.5 АГ ХК-ийн ХЭХ-ын болон ТУЗ-ийн үйл ажиллагааны 2020 оны зардлын төсвийг хэлэлцэж батлах
 - 2.6 Компанийн дүрэмд компанийн оршин байрлах хаяг өөрчлөгдсөнийг тусгаж шинэчлэн батлах.
3. Хурал хуралдуулах тухай мэдэгдлийг Санхүүгийн зохицуулах хороо МХБ-д мэдэгдэх өдрийг 2020 оны 3 дугаар сарын 12-ны өдрөөр, хувьцаа эзэмшигчдэд зарлах өдрийг 2020 оны 3 дугаар сарын 13 болон 3 дугаар сарын 27-ний өдрүүдээр тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2020 оны 3 дугаар сарын 23-ны өдрөөр тогтоосугай.
5. Энэ тогтоолын 3-т заасан нийтэд зарласан өдрөөс буюу Монголын Хөрөнгийн биржийн цахим хуудсанд байршуулах өдрөөс хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокерийн компанид хурлын материалыг хүргүүлэх, эхний болон давтан зарыг өдөр тутам хэвлэгдэн гардаг 2-оос доошгүй сонинд 2 удаагийн давтамжтай хэвлүүлэх, радио, телевизээр мэдээлэх зэргээр хурлын зарыг хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэхийг Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
6. Дараах бичиг баримтуудыг компанийн байр болон хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг брокер дилерийн компаниуд дээр бэлэн байлгаж, хувьцаа эзэмшигчдэд хурал хуралдахаас өмнө танилцуулах ажлыг зохион байгуулсугай. Үүнд:
 - 6.1. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоолын хуулбар;
 - 6.2. Хурлаар хэлэлцэх асуудлуудаар гарах шийдвэрийн үндэслэл болох үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан;
 - 6.3. Хурлын санал хураах хуудас.
 - 6.4. ТУЗ-ийн энгийн болон хараат бус гишүүдийн тухай танилцуулга

6.5 ТУЗ-ийн болон ХЭХ-ын 2020 оны зардлын төсөв

6.6 Хувьцаа эзэмшигчдэд 2019 оны цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилахаар шийдвэр гаргасан тухай ТУЗ-ийн 07/20 тоот тогтоолыг ХЭХ-аар хэлэлцүүлж дэмжүүлэх

6.7 Ариг гал ХК-ийн хаягийн өөрчлөлтийг тусгаж шинэчилсэн дүрмийн төсөл

7. Хурлын санал хураах хуудасны загварыг энэхүү шийдвэрийн Хавсралт №1-ээр баталсугай.

8. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг хурал хуралдах өдрийн буюу 2020 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 12 цагаар тогтоосугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар ТУЗ-ийн гишүүн Д.Мөнхбатыг, хурлын тооллогын комиссын даргаар Ч.Энхцэцэгийг томилсугай.

10. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга материал, хурлаас гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахыг Хурал зохион байгуулах комисс /Д.Мөнхбат/-т даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

С.МӨНХЖАРГАЛ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮН

Б.БОЛД

Б.АЮУШ

Б.ЁНДОНЖАМЦ

Э.БЯМБАЖАВ

Д.ГИВААПИЛ

С.АЛИМАА

Д.МӨНХБАТ

Х.ХАНИЯ